

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ,ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Нийслэлийн Эрүүл мэндийн газар "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага,албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлт, саналыг төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандартыг баримтлан хуулийн хугацаанд, шуурхай шийдвэрлэж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж дотоод хяналт тавьж ажиллаж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт **1541** өргөдөл, гомдол, хүсэлт ирснийг **97** хувьтай шийдвэрлээд байна. Үүнээс **1497** гомдол хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, судлаж шийдвэрлэх шатандаа **44** өргөдөл гомдол хүсэлт байна.

- 1.Гомдол-1025
- 2.Санал-34
- 3.Хүсэлт-417
- 4.Талархал-65

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хоног өнгөрсөн оны (2024 он) жилийн эцсийн байдлаар дундаж хугацаа 12 хоног 3 цаг 22 минут байсан бол 2025 оны 12 сарын байдлаар 26-ны 11 хоног 08 цаг 15 минут болж хэлтсүүдийн шийдвэрлэлтийн дундаж хугацааны тайланг ангилахад өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1 хоног, 2 цаг, 0 минутаар эрс буурсан үзүүлэлттэй байна.

№	Хэлтэс, нэгжийн нэрс	тоо	Дундаж хоног.
1	Удирдлага	0	-
2	Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэс	188	11 хоног 4 цаг 11 минут
3	Эрх зүй,тусгай зөвшөөрлийн тасаг	14	1 хоног 8 цаг 53 минут
4	Хамтын ажиллагаа, зохион байгуулалтын тасаг	9	4 хоног 3 цаг 41 минут
5	Санхүү, хөрөнгө оруулалтын тасаг	14	14 хоног 3 цаг 59 минут
6	Төлөвлөлт,хяналт-шинжилгээ,үнэлгээ,дотоод аудитын хэлтэс	0	-
7	Төлөвлөлт, эдийн засгийн тасаг	0	-
8	Хяналт-шинжилгээ,дотоод аудитын тасаг	3	12 хоног 18 цаг 4 минут
9	Нийтийн эрүүл мэндийн өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтэс	22	14 хоног 14 цаг 12 минут
10	Эрүүл мэндийн боловсрол, нийгмийн эрүүл мэндийн сүлжээний үйлчилгээний тасаг	0	-
11	Ноцтой байдал, халдварт болон зоонозын өвчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын тасаг	9	7 хоног 10 цаг 50 минут
12	Эмнэлгийн тусламжийн хэлтэс	433	7 хоног 0 цаг 50 минут

13	Анхан шат, цахим эрүүл мэндийн тасаг	46	10 хоног 20 цаг 37 минут
14	Эрүүл мэнд, эмнэлгийн техник хэрэгслийн инновацийн тасаг	28	10 хоног 3 цаг 40 минут
15	Эрүүл мэндийн хяналтын хэлтэс	623	14 хоног 15 цаг 49 минут

Нийслэлийн эрүүл мэндийн газарт ирсэн өргөдөл гомдол:

- Засгийн газрын 11-11 төвөөс 969
- ННЗБ-д -400
- Засгийн газрын 1800-1200-аас -154
- НҮНТөв –11
- Онлайн бизнес төв- 1
- E-Servise –4
- Хороо-1 үйлчилгээгээр шилжин ирсэн байна.

Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ 1059 гомдлыг иргэний талд, 436 өргөдөлд боломжгүй тухай хариу өгсөн бөгөөд албан бичгээр 393, утсаар 865, мессеж буюу цахим харилцаагаар 115 хариуг өгч, 124 иргэнтэй биечлэн уулзаж гомдлыг шийдвэрлэсэн байна.

Өргөдөл гомдлын хандалтаас үзэхэд ӨЭМТ болон эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, тамхины зөвшөөрөлд ажлын байрны дүгнэлт гаргуулах, хоолны газар, баар рестораны үйлчилгээ, эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналт, зах болон худалдааны төв, үйлчилгээний байгууллагын тухай, орон сууцны 1 дүгээр давхарт байрлах үйлчилгээний газрууд, ил задгай худалдаа, үйлчилгээ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, хүнсний чанар, аюулгүй байдлын хяналт, эрүүл мэндийн салбарын албан хаагчийн ёс зүйн тухай, яаралтай тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн салбарын цалин, хөлс, ажлын сахилга, хариуцлагын тухай, нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай, худалдаа, үйлчилгээний тухай, хог хаягдал шатаах, усны шинжилгээ хийлгэх, орчны эвгүй үнэр, орчны бохирдолтой холбоотой гомдол нийт гомдлын 92.52 хувийг эзэлж байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газарт иргэдээс гаргасан 1541 гомдолд дүн шинжилгээ хийж шалтгаан нөхцлийг тодруулахад: Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч нарын ур чадвар, харилцаа хандлага, ёс зүй муу, мэдээллээ үнэн зөв өгдөггүй, буруу онош тавьдаг, алдаа дутагдал гаргадаг, жирэмсний хяналтад ороход хүндрэл чирэгдэл үүсгэдэг, өрхийн эмнэлэгт орчин үеийн үзлэг оношилгооны аппарат, тоног төхөөрөмж техник хэрэгсэл дутмаг, ажиллах цагийн хуваарь нь бага, дугаарлаж олон цагаар үйлчлүүлдэг, өдрийн эмчилгээ болон гэрийн эргэлтээр нярай хүүхэд, ахмад настандаа тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хангалтгүй, дархлаажуулалт болон вакцинжуулах ажил учир дутагдалтай байгаа тухай гомдлуудыг гаргасан байна.

Мөн лавлагаа шатлалын буюу хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын ачаалал их, эмч нар хүрэлцээгүй, эмчилгээний ачаалал их, үзлэгийн болон шинжилгээний цаг авч чаддаггүй, жирэмсний хяналт сул, шинжилгээнүүдийн төлбөр өндөр, группт орох болон сунгах хурлын зохион байгуулалт муу, хурлаар орж буй иргэддээ мэдээлэл өгдөггүй, тайлбарладаггүй, өрх болон салбар амбулаторийн дунд иргэдийн ийш тийш нь явуулж чирэгдэл учруулдаг, харьяаллын бус гээд үздэггүй, лавлах утсаа авдаггүй, лавлагаа мэдээллийн ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, эм тарианы нөөц хомс, эм тариа

утлагын бодис, бинт боолт зэргийг иргэнээр гаднаас авхуулдаг, нарийн мэргэжлийн эмч нар байхгүй зэрэг нь гомдол гарах шалтгаан нөхцөл болж байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, гомдол гарч буй шалтгаан нөхцлийг харьяа байгууллагуудын удирдах ажилтны шуурхай хуралдаануудад тогтмол мэдээллийг хүргүүлж НЭМГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны 01 дугаартай Албан даалгаварт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 6 асуудлаар үүрэг даалгаварыг 28 байгууллагад хүргүүлэн ажилласнаар харьяа эрүүл мэндийн байгууллагын гомдол шийдвэрлэлт дундаж хугацаа 2-6 хоногт болсон.

Зөрчлийн тоо жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 145 байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийн 578 зөрчилтэй харьцуулахад нийт зөрчлийн тоо 433 зөрчлөөр эрс багассан сайн үр дүнтэй байна.

2025 оны зөрчлийн үзүүлэлтийг ангилвал:

Явцын тэмдэглэл хөтлөөгүй-68

Өдөрт нь багтаан шилжүүлээгүй-45

Өдөрт нь багтаан хүлээн аваагүй-31

Буцаалтыг 3 хоногт хийгээгүй-1

Байгууллагын хамт олны 3 удаагийн хурлаар өргөдөл гомдлын явц, зөрчлийн мэдээллийн танилцуулга хийж, зөрчил гаргасан мэргэжилтэн, хэлтсийн дарга нарт сануулж, гомдлын хугацаа дуусах өргөдлийг мэргэжилтэн тус бүрээр биечлэн цахим сүлжээгээр сануулан ажиллаж байна. Хэлтсийн болон мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өргөдөл гомдлын шийдвэрлэлт, дундаж хугацаа, зөрчлийг тусгуулан 2025 оны жилийн үнэлгээгээр хэлтэс тус бүрийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа эрс буурсан, 3 улирлын тайлангаас хойш зөрчлийн тоо мөн буурсан байна.

НЗДТГ-аас ирүүлсэн "Чиглэл хүргүүлэх тухай" 03/4008 дугаартай албан бичигт дурьдсан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад удаа дараа зөрчил гаргасан албан тушаалтан, албан хаагчдад хариуцлага тооцох чиглэлийн дагуу хэлтсийн дарга нар болон ахлах мэргэжилтнүүдийн өргөтгөсөн хурлыг хийж, 1 дүгээр улирал болон 3 дугаар улирлын байдлаар хэлтэс тус бүрээр хэлэлцэн удаа дараа зөрчилд орсон албан хаагчдад хурлын тэмдэглэлээр сануулга өгөв. **(Хурлын тэмдэглэлийг хавсаргав)**

Мөн байгууллагад шинээр ажилд орсон 15 албан хаагчдад **"Өргөдөл гомдлын дэд системийн хэрэглээ анхаарах асуудал"**сэдэвт сургалт зохион байгуулж, Аддиктологийн төв, Хан-уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар нэгдсэн эмнэлгийн өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд биечлэн, Гачуурт тосгон, Хүрээ, Амгалан, Өргөө амаржих газрын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнүүдэд цахимаар өргөдөл гомдлын ERP системд хэрхэн ажиллах, НЗД-ын захирамжаар батласан өргөдөл гомдлын 1049 дүгээр журмыг танилцуулж мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.

2024 оны жилийн эцсийн байдлаар хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 14 өргөдөл гомдол байсан бол энэ оны байдлаар 4 өргөдөл гомдол байна. Тус зөрчлийг гаргасан албан хаагчдыг тухай бүр зөрчлийн тайлбарыг авч Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлсэн. Энэ тухай ЭМХХ-ийн хурлаар оруулж, М.Галбадрах улсын байцаагчид ганцаарчилсан хэлбэрээр сануулга өгсөн. НЗДТГ-аас НЗД-ын 2 дугаар сарын 20-ны өдрийн А/42 тушаалтай удирдамжтай шалгалтын ажлын хэсэгт энэ тухай танилцуулсан.

Мөн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 1,2,3 улирлын тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллалаа.

Нийслэлийн эрүүл мэндийн газарт давтамжтай ирсэн эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдлуудад дүн шинжилгээ хийж, Эмнэлгийн тусламжийн хэлтсээс дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол эрсдэлийг бууруулах тусламжийн чанар сайжруулах чиглэлээр харилцан туршдагаа солилцох чиглэлээр 2025 оны 3 дугаар сард харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын дарга нарт Хан уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн "Чихрийн шижингийн нэг цэгийн үйлчилгээ" сайн туршлагыг заавал хэвшүүлэх бүтээлийн танилцуулга ажлыг зохион байгуулав.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гомдлыг бууруулах бууруулах, давтан гарахаас сэргийлэх, чанар сайжруулах төлөвлөгөө боловсруулах арга барил олгох онол, дадлагын сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Өргөө амаржих газар зохион байгуулж, ЭМТҮЧАБА-ны дарга, чанарын орон тооны бус гишүүд нийт 61 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 2024 оны 10, 11 дүгээр сард бүртгэгдсэн эх барихын болон хүүхдийн тусламж, үйлчилгээтэй холбоотой ноцтой тохиолдлын эрсдлийн үнэлгээ, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/112 тушаалын дагуу төлөвлөгөө боловсруулах арга аргачлалыг танилцуулж, байгууллагын чанарыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах дадлага хийлгэв.

Эмч нарын харилцаа хандлага, ур чадвар, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх чиглэлээр:

1.НЭМГ-аас "Тусламж үйлчилгээний чанар сайжруулахад эмч, эмнэлгийн мэргэжилтний оролцоо", "Эрсдэл", "Тохиолдол бүртгэл, хариу арга хэмжээ", "Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээнд тавигдах шаардлага" зэрэг нийт 4 сэдвээр 11 эрүүл мэндийн байгууллагад 12 удаагийн танхимийн сургалт зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор 328 эмч эмнэлгийн мэргэжилтэн оролцов.

2.Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу Яаралтай тусламжийн "Дуудлага-2" тэмцээнийг 2025 оны 06 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд 2 бүс болгон 2 үе шаттай зохион байгуулсан. Нийт 14 багийн нийт 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон байна. Энэхүү тэмцээн нь эрүүл мэндийн байгууллагуудын Яаралтай тусламжийн чиглэлээр хийсэн үр дүнтэй томоохон ажлын нэг болов.

3.НЭМГ-ын даргаар батлуулсан "Гомдол болон тохиолдолд суурилсан цахим хэлэлцүүлгийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 14 хоног тутам гомдлын мөрөөр цахим хурал хийж, 6 дугаар сарын 10-ны байдлаар нийт 12 сэдвээр 8 удаагийн хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 2814 цэгээс 5000 эмч, мэргэжилтэн оролцоод байна.Тус хэлэлцүүлгийг ХӨСҮТ, ЭХЭМТҮ, УГТЭ, УГТЭ болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийг оролцуулж байгаа нь гомдлын мөрөөр хийсэн үр дүнтэй ажлын нэг болж байна.

4.Жирэмсний эрт хяналтыг сайжруулах, ургийн гажгийн эрт илрүүлэх төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын уялдаа, мэдээлэл солилцолт сайжруулах чиглэлээр 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр 8 дүүргийн эрүүл мэндийн төв, 3 амаржих газар болон нийслэлд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн 38 эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл оролцсон хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр жирэмсний хяналтад ороогүй, ургийн гажиг илэрсэн, архаг суурь өвчлөлтэй жирэмсэн эхийн мэдээллийг солилцох шийдэлд хүрсэн. "Жирэмсэн эхийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж үйлчилгээг сайжруулах" зорилгоор 2025 оны 5 дугаар сард Нийслэлийн түргэн тусламжийн төвийн нийт эмч нарыг 3 амаржих газруудад хуваарилан дадлага сургалтыг зохион байгуулав.

5.Нийслэлийн харьяа Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар харьяалал харгалзахгүй хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлдэг болсон. Нийслэлийн Өргөө амаржих газар 2025 онд

Эрсдэлтэй жирэмсний орыг /60 ортой байсан/ 73%-аар нэмэгдүүлж нийт 104 ор, дутуу төрөлтийн хэвтүүлэн эмчлэх 65 ортой тасаг шинээр нээж эрхтэн тогтолцооны суурь эмгэгтэй эрсдэлтэй, дутуу төрөхийг завдсан жирэмсэн эхэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

НЭМГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтэст иргэнээс гаргасан хүсэлт өргөдөл гомдлуудыг судлахад:

Хоолны газар, баар рестораны эрүүл ахуй, халдвар хамгаалын тухай, хүнсний бүтээгдэхүүний чанар, хоолны хордлого, орчны дуу чимээ, эрүүл ахуй, 1 давхарт байрлах ресторан, хоолны газруудын гомдол, тамхи худалдаалах тусгай зөвшөөрөлд ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлт дийлэнх хувийг эзэлж байна.

Гомдол хүсэлтийн мөрөөр Эрүүл мэндийн хяналтын хэлтэс тайлант хугацаанд нийт 642 өргөдөл, гомдол хүлээн авснаас 623 буюу 97 %-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгсөн. Хугацаа болоогүй шийдвэрлэх шатанд байгаа 19 өргөдөл гомдол байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт нийт 6102 байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 873 зөрчил дутагдал илрүүлэн, 617 буюу 70% -ийг арилган, 153 хуулийн этгээд, иргэнд 109,500.000 төгрөгийн шийтгэл ногдуулж бүрэн барагдуулан, эмчлэх эрхийн тусгай зөвшөөрөлгүйгээр ажилласан хуулийн этгээдэд хууль бусаар олсон 830.592.900 төгрөгийг улсын орлого, болгох шийдвэр гаргуулж, 60%-ийг барагдуулсан байна.

Мөн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтад 2025 онд хамрагдахаар зарлагдсан хүнсний үйлдвэр, худалдаа, нийтийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 132 аж ахуй нэгжид, хүүхдийн эрүүл ахуйн чиглэлээр 31 удирдлага, эмч нарт арьс, гоо зсалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 18 эмнэлгийн 150 эмч, мэргэжилтэнд, зочид буудал, гоо сайхан, үсчний үйлчилгээ эрхлэгч 126 хуулийн этгээд, иргэнд холбогдох хууль дүрэм, журам, стандарт, цэвэрлэгээ халдваргүйтгэл, халдваргүйтгэлийн бодисын хэрэглэх аргууд, дотоодын хяналт сэдвээр батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж, санал солилцсон байна.

Иргэдээс өрх болон дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудад орчин үеийн үзлэг оношилгооны аппарат, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг хангалтгүй байгаа тухай санал, хүсэлт тогтмол ирдэг бөгөөд энэ хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин, тавилга эд хогшил худалдан авахад шаардлагатай нийт 28.2 тэрбум төгрөг батлагдсан.

Дээрх төсвийн хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа 27 эрүүл мэндийн байгууллагад (Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Баянзүрх дүүргийн ахмад настан хүүхдийн эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн төв, Нийслэлийн Хүрээ амаржих газар, Нийслэлийн Амгалан амаржих газар, Нийслэлийн Өргөө амаржих газар, Жаргалант тосгоны эрүүл мэндийн төв, Чингэлтэй нэгдсэн эмнэлэг, Гачуурт тосгоны эрүүл мэндийн төв, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв, Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн хүүхдийн амбулатори, Налайх дүүргийн эрүүл мэндийн төв, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв, бусад харьяа эрүүл мэндийн байгууллага) нийт 25.3 тэрбум төгрөгөөр эмнэлгийн тоног төхөөрөмжийг (тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил) шинэчлэн ашиглалтын чанарыг сайжрууллаа.

Цаашид өргөдөл гомдлыг бууруулах чиглэлээр:

Эрүүл мэндийн газарт ирсэн гомдлын 30-аас дээш хувийг ӨЭМТ-н үйл ажиллагаатай холбоотой, өдрийн эмчилгээтэй холбоотой гомдол эзэлдэг бөгөөд гомдол шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа нь өдрийн эмчилгээний хязгаарлалтаас шалтгаалж байна. Даатгалын Ерөнхий газар Өрхийн эрүүл мэндийн төвийн өдрийн эмчилгээд хязгаарлалт тогтоосон тул

өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлдэг ахмад настан болон хяналтанд байдаг үйлчлүүлэгч /архаг өвчтэй/ өдрийн эмчилгээнд хамрагдах боломжгүй байна. иймд тус хязгаарлалтыг судлах, эрүүл мэндийн даатгалын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах саналтай.

Иргэдээс Дүүргийн эрүүл мэндийн төв, Хүүхдийн сувилал, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд нарийн мэргэжлийн эмч нар дутагдалтай, хүний нөөцийн хомсдол, тэтгэмжийн асуудлаар удаа дараа гомдол ирдэг. АШУИС, ЭМЯ, Эрүүл мэндийн хөгжлийн төв, нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон салбар дундын уялдаа холбоо муу, улсын санхүүжилтээр сурах нарийн мэргэжлийн эмч нарын нийслэл дэх сургалтын квот бага, цалин хөлс урамшуулал, нийгмийн баталгаа хангалтгүй, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн ажилтнуудад олгодог тэтгэмжийн асуудал шийдвэрлэхэд удаашралтай дараа оны төсөвт суугддаг тул хүсэлт өгсөн ажилтнууд жил дамнан хүлээх шаардлага тулгардаг тул Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах, хууль эрхзүйн орчныг өөрчлөх шаардлагатай байна.

Орон сууцны 1 дүгээр давхарт байрлах хоолны газраас үнэр, хиншүү үнэртэж байдаг, хоолны газруудын хөргүүрийн дуу чимээ, цахилгаан шатны дуу чимээ гэдэг гомдол оршин суугчдаас маш ихээр ирдэг. Хуучны нэг давхарын орон сууцнуудад агааржуулалт нэг учраас дээд давхарын айлуудад хиншүү үнэртдэг. Тус хэлтэст ирүүлсэн гомдлын 25 хувийг дээрх гомдол эзэлж байна. Иймд эрүүл ахуйн тухай хуулинд орон сууцны нэг давхарт зориулалтын бус байранд хоол, үйлдвэрлэл үйлчилгээ явуулахгүй байхаар тусгах, эрхзүйн орчныг зохицуулалт хийх, орон сууцны үзэлийн болон цахилгаан шатны дуу чимээ нь барилга байгууламжийн хийц бүтээц, тоног төхөөрөмжийн угсралттай холбоотой байдаг тул барилгын тухай хуульд нэмэлт оруулах, барилгын техникийн хяналтын улсын байцаагч хуульд заасан чиг үүргийн дагуу шийдвэрлэх

Иргэдийн урьдчилэн сэргийлэх Эрт илрүүлэг хөтөлбөр эхлэх үеэр эмнэлэгт үзүүлэх сонирхолтой хүний тоо эрс нэмэгдэж, ачаалал үүсэх хандлага байдаг. Эрт илрүүлгийн талаар иргэдийн гаргасан гомдолд дараалал их байгаа, хүлээгдэл үүсдэг тухай их дурддаг

Энэ тохиолдолд эрт илрүүлгийн цахим программтай болох, хүн амыг эрт илрүүлэг болох хугацаанд хувиарлаж иргэнд автоматаар сануулсан мсж очдог, эмнэлгийн байршил, үзүүлэх өдрийг нь зааж өгдөг. Ямар бэлтгэлтэй ирэхийг мэдээлдэг аппликэшн эсвэл мэдээллийн программ байвал гомдол гаргахгүй байх, эмнэлгийн ачааллыг жигд болгох боломжтой болно юм.

Цаашид эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, харьцаа хандлага, ёс зүйн талаар сургалтыг нэмэгдүүлэх, даатгалын ерөнхий газраас дүүргийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн өдрийн эмчилгээд хязгаарлалт тогтоосон тул өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлдэг ахмад настан болон хяналтанд байдаг үйлчлүүлэгч /архаг өвчтэй/ өдрийн эмчилгээнд хамрагдах боломжгүй болсон тул хууль эрх зүйн орчныг судлах, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

ХЯНАСАН: ЗНУХ-ИЙН ДАРГА У.БАТ-ОЧИР

ТАЙЛАН ГАРГАСАН: МЭРГЭЖИЛТЭН Д.НАРАНТУУЛ

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

2025 он